



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ДУЛААНЫ СУЛЖЭЭ ТӨХК-ИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/62/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2018 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

Г "УЛААНБААТАР ДУЛААНЫ СУЛЖЭЭ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БЯМБА-ОЧИР ТАНАА

2018.03.15 № 06/703
таний -ны № -т

Г Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланда санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *З.Мж* Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122

**“УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ”
ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512 Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

Баян суварга Аудит” ХХК-ийн захирал С.Должинсүрэн

Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Аудитор Х.Тунгалагтуяа
Утас: 99176599 Цахим хаяг: h.tungalagtuya@yahoo.com

Аудитор Н.Бат-Оюун
Утас: 99192138 Цахим хаяг: nbton57@yahoo.com

Улаанбаатар хот

АГУУЛГА

1 Аудитын гэрчилгээ	1
2 Аудитын тайлан	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5 Дотоод хяналт	6
2.6 Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлтийн талаар	7
2.7 Шилэн дансны мэдээлэл	7
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1 Авлагын бүртгэл, тайлагналын талаар	8
2.9.2 Бараа материалын бүртгэл, тайлагналын талаар	9
2.9.3 Актлаж данснаас хассан хөрөнгийн талаар	10
2.9.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналын талаар	10
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	11
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	11
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	12
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3 Менежментийн захидал	13
3.1 Авлагын бүртгэл, тайлагналын талаар	14
3.2 Бараа материалын бүртгэл, тайлагналын талаар	16
3.3 Актлаж данснаас хассан хөрөнгийн талаар	17
3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналын талаар	18
4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	20
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	20
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	21

2 Аудитын тайлан

2.1 Оршил

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Бямба-Очир танд танилцуулж байна.

Энэхүү тайланда танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн унэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлан тооцооны талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланда аудит хийллээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчтэй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн удирдлага тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан нь дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланг 01 зорчилгүй санадлынгийн аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар 2018 оны 2 дугаар сарын 26-наас 2018



оны 3 дугаар сарын 15-ны хооронд “Баян суварга аудит” ХХК-ийн аудиторууд хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Сангийн яам, ЭХЗХороо, ТӨБЗГазар, ЭХЯ-нд тус тус хүргүүлсэн бөгөөд “Баян суварга Аудит” ХХК-д 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн болно.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1959 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 367 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Дулааны шугам сүлжээний газар” нэртэй /“УБДШСГ”/-гээр анх байгуулагдан, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор биеэ даасан “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн хэлбэрт шилжин ажиллаж байна.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Нийслэл хотын төвлөрсөн дулаанд холбогдсон хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах, түгээх, шугам тоноглолын засвар үйлчилгээг чанартай хийж үйлдвэрлэлийг найдвартай явуулах;
- Дулааны эрчим хүчний борлуулалтын үнэ өртгийг бүрэн цуглуулах;
- Дулааны эх үүсвэрт боловсруулсан дулааны эрчим хүчний чанарт байнгын хяналт тавьж алдагдалгүй дамжуулах;
- Төвлөрсөн дулаан хангамжинд шинээр холбогдох хэрэглэгчийн захиалгыг судлан барилга, объектын техникийн нөхцлийг зохих журмын дагуу олгож хэрэгжилтэнд нь хяналт тавих;
- Хэрэглэгчийн дулааны шугам тоноглолын засвар, үйлчилгээг чанартай хийлгэж өвлийн их ачааллыг амжилттай давах, дулааны эрчим хүчний ашиглалтад тогтмол хяналт тавьж зүй бус хэрэглээг бууруулах, хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна.

Компанийн ТУЗ-ийн 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар тогтоолоор бүтэц, орон тоог шинэчлэн 14 алба, хэлтэс нэгжтэй 365 орон тоотой ажиллахаар батлаж, гүйцэтгэлээр 365 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон аж ахуйн гэрээтэй хэрэглэгчид, барилга объектын халаалт, салхилга, хэрэгцээний халуун усны дулааны эрчим хүчний хэрэглээг “Амгалан дулааны станц” ХХК, “ДЦС-2”ХК, “ДЦС-3”, “ДЦС-4”ХК-иудад боловсруулсан дулааны эрчим хүчээр найдвартай ханганд ажиллаж байна.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2017 оны 01 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруултын бэлтгэх



заавар"-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд балансын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 24 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.


"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК нь санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаандаа тус компанийн Гүйцэтгэх захирлын 2015 оны А/35 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бodoх бүртгэлийн бодлого", Эрчим хүчний сайдын 2017 оны 46 дугаар тушаалаар баталсан эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчit аж ахуйн нэгж, байгууллагуудын мөрдөх "Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг тус тус мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна.

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК нь санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаандаа "Интерактив Би Ай" ХХК-ийн нягтлан бodoх бүртгэлийн Даймонд 3.0 програмыг ашиглаж байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй тэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нэлээстэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.



Компанийн дотоод аудитаас тайлант онд дулааны эрчим хүчний хугацаа хэтэрсэн авлага барагдуулахад голчлон анхаарч ажилласны зэрэгцээ 2017 оны эхний хагас жилийн цагийн бүртгэл, цалин, нэмэгдлийн тооцоолол, албан томилолтын зардлын төсөв, гүйцэтгэл, тооцоололд шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлтийн талаар

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 229 дүгээр тогтоолоор баталж, 2017 оны 397 дугаар тогтоолоор тодотгол хийн шинэчлэн баталсан байна.

Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 2017 онд 93,090.9 сая төгрөгийн орлого олж, 92,701.3 сая төгрөгийн зардал гарган, 389.6 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 92,866.1 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 91,686.4 сая төгрөгийн зардал гаргаж, 1,179.7 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардалд 166.5 сая төгрөг төлөхөөр гарч 1,013.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Татварын өмнөх ашиг төлөвлөгөөнөөс 790.1 сая төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оноос 1,702.9 сая төгрөгөөр буурсан. Ашиг төлөвлөгөөнөөс нэмэгдэхэд түгээх, хангах үйл ажиллагааны зардлыг 5.7 хувиар буюу 1,293.6 сая төгрөгөөр хэмнэсэн, үндсэн бус үйл ажиллагааны орлого 278.4 сая төгрөгөөр давж биелсэн, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг 35.4 сая төгрөгөөр хэмнэсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Үндсэн үйл ажиллагаагаар 10.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж 466.0 сая төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оноос 1,817.1 сая төгрөгөөр буурч, төлөвлөгөөнөөс 476.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 800.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 1,078.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 134.8 хувиар буюу 278.4 сая төгрөгөөр давж биелсэн.

Тус компани 2017 онд Улаанбаатар хотын иргэд, аж ахуйн нэгжийн 2814 хэрэглэгчдэд 92,290.9 сая төгрөгийн дулааны эрчим хүч борлуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 91,787.7 сая төгрөгийн дулааны эрчим хүч борлуулж 503.2 сая төгрөгөөр төлөвлөсөнөөс дутуу борлуулсан. Энэ нь 2017 онд түгээлт 6,138.3 мян.гкал дулааны эрчим хүч түгээхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,806.1 мян.гкал дулааны эрчим хүч түгээсэнтэй холбоотой байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 384 тоот тогтоолыг хэрэгжүүлж, Эрчим хүчний яамны шилэн дансны цахим хуудас [/www.shilendans.gov.mn/](http://www.shilendans.gov.mn/)-т тус компанийн нэрээр нэвтрэн тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг холбогдох 7 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд нь оруулан ажилласан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт 38, хяналтын 21 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлт үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:


2.9.1 Авлагын бүртгэл, тайлагналын талаар

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК 2017 оны 12 сарын 31-ний байдлаар ОСНААУГ-аас 1548-MON(SF) дугаартай Дулааны үр ашгийн төслийн дамжуулан зээлийн гэрээний 1,398.2 сая төгрөг, 1492-MON(SF) дугаартай Эрчим хүчний хэмнэлтийн төслийн дамжуулан зээлийн гэрээний 125.1 сая төгрөг нийт 1,523.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд нийт авлагын үлдэгдлийн 40.1 хувийг эзэлж компанийн эдийн засгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь тус компани 2007-2008 онд ОСНААУГ-ын өмнөөс Сангийн яаманд төлсөн төлбөр бөгөөд авлага барагдуулах талаар ОСНААУГ-т удаа дараа хандсан боловч төлбөрийн чадвар байхгүй гэсэн шалтгаанаар төлөгдөөгүй өдий хүрсэн байна.

2. Азийн хөгжлийн банкны урт хугацаат дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Эрдэнэт-Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-тай байгуулсан гэрээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүйгээс 2017 оны эцэст зээл, зээлийн хүүгийн 24.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3. Компанийн ТҮЗ-ийн 2015 оны 25 дугаар тогтолцоо 2015 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитыг “Голден пэйж Аудит” ХХК-ийн аудитчийн байгууллага сонгон шалгаруулан урьдчилгаа төлбөрт 9.0 сая төгрөг төлж байгаа ажлыг эхлүүлсэн боловч Үндэсний аудитын газраас “Ворлд файнэншил Аудит” ХХК-ийн аудит хийлгэх албан бичиг ирүүлснээр “Голден пэйж Аудит” ХХК-ийн аудитын



ажил цуцлагдаж, улмаар 6.0 сая төгрөгийг буцаан төлж, үлдэгдэл 3.0 сая төгрөгийг аудит хийсэн ажилтнуудын ажлын хөлс гэсэн үндэслэлээр төлөхөөс татгалзсан байна.

4. Тус компани тайлант оны эцэст 92 аж ахуйн нэгж байгууллагаас авах дулааны эрчим хүчний төлбөр 193.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Төслийн зээлийн гэрээний авлагын 1,523.3 сая төгрөгийн асуудлыг аудитаар агуулгын хувьд буюу шинж чанарын хувьд материаллаг бус гэж узсан бөгөөд Эрчим хүчний зохицуулах хороо, ОСНААУГ-тай зөвшилцэн дулааны үнэ тарифт зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг компанийн удирдлагад зөвлөмж болгох.


2. “Эрдэнэт-Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-иас авах дамжуулан зээл, зээлийн хүүгийн 24.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ авч ажиллах,
3. “Голден пейж Аудит” ХХК-иас авах 3.0 сая төгрөгийн авлагын асуудлыг шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх,
4. 92 аж ахуйн нэгж байгууллагаас авах дулааны эрчим хүчний төлбөрийн 193.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулан барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг тус компанийн удирдлагад зөвлөмж болгох.

2.9.2. Бараа материалын бүртгэл, тайлагналын талаар

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан хөрөнгийн тайлан тооцоог шалгаж үзэхэд 2017 онд үндсэн хөрөнгийн шинж чанартай 5 төрлийн нийт 7.0 сая төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг тоног төхөөрөмж /үүнд: аяга таваг угаагч төхөөрөмж-2, цаас устгагч-1, гагнуурын аппарат-2, трансформатор-3, ацителиний ком аппарат-2 ширхэг/-ийг худалдан авч бараа материалын дансанд бүртгэн зарлага болгосон байна.

Энэ нь Эрчим хүчний сайдын 2017 оны 46 дугаар тушаалаар баталсан эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 9 дүгээр зүйлийн 9.3-д “үндсэн хөрөнгө гэдэг нь нэгээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдах үйлдээрлэл, үйлчилгээ буюу захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр оршиж байгаа /Оригин байх/ тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр байгууллагад хамаатай байх /Эрх ба урэг/, хөрөнгө, өр төлбөрийг зохих бүртгэлийн үнээр нь бүртгэсэн байх /Үнэлгээ/, ажил бүйгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллага, хууль тогтоох байгууллага, Сангийн яамнаас гаргасан дүрэм



журамд нийцэж байх үнэн зөв байдал/ зэрэг санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансанд бүртгэн зарлага болгосон 5 төрлийн нийт 7.0 сая төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авахыг компанийн удирдлагад зөвлөмж болгох.

2.9.3. Актлаж данснаас хассан хөрөнгийн талаар

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар /ТӨБЗГ/-ын 2016 оны 229, 2017 оны 397 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тайлант онд нийт 4,275.2 сая төгрөгийн өртөгтэй 3228 хос метр дулааны шугамыг шинэчлэн солихоор тусгасан байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2017 оны зуны их засвараар нэр бүхий 34 байршилд ашиглагдаж байсан нийт 2,427.5 сая төгрөгийн өртөгтэй 3,622.5 хос метр дулааны хуучин шугамыг сольж, актлаж данснаас хасах саналыг 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 09/2441 дүгээр албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн болов ч тухайн ондоо шийдвэр нь гарагүй бөгөөд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 32 дугаар тогтоолоор данс бүртгэлээс хассан байна.


Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1-д “Төрийн өмчт хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг актлаж данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Актлаж данснаас хассан 2,427.5 сая төгрөгийн өртөгтэй 3,622.5 хос метр дулааны хуучин шугамын асуудлыг аудитаар агуулгын хувьд буюу шинж чанарын хувьд материаллаг бус гэж үзсэн бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт дахин тавьж холбогдох шийдвэрийг гаргуулж авахыг компанийн удирдлагад зөвлөмж болгох.

2. Цаашид үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй шугам хоолой болон бусад хөрөнгийг актлаж данснаас хасахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох зөвшөөрөл шийдвэр авч байхыг компанийн удирдлагад зөвлөмж болгох.

2.9.4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналын талаар

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК 2009-2016 онд ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн оны их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж Төрийн өмчийн хороогоор батлуулан нийт 1,078.2 сая төгрөгийн үнэ бүхий 1-2 өрөө 28 ширхэг орон сууцыг худалдан авч тухайн ажилтнуудад 50-иас 100 хувийн хөнгөлөлттэй үнээр төлжид Орон гулагаа эзэмшүүлэх тухай гэрээ” байгуулан компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн бөгөөд орон сууцны Улсын бүртгэлийн тэрчилгээний зөвлөмжийн хүмүүсийн нэр дээр бүртгэлтэй байна.



Эдгээр орон сууцыг тухайн онуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан гэсэн утгаар компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэж ирсэн бөгөөд бүтээмжийн зориулалттай бус ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн зардлын шинж чанартай хөрөнгө болох нь тогтоогдож байна. /Энэхүү асуудлыг аудитаар агууллын хувьд буюу шинж чанарын хувьд материаллаг бус гэж үзсэн болно./

Энэ нь “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 3 дугаар зүйлийн 3.4 “Үндсэн хөрөнгийн бодлого”-ын Тодорхойлолт хэсэгт “... бүтээгдэхүүн ажил үйлчилгээний зорилгоор ашиглагдаж, элэгдлийн үндсэн дээр өртөг зардалд анхны үнээ аажмаар шингээж байгаа биет хөрөнгүүдийг хамааруулна”, Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт хэсэгт “Үндсэн хөрөнгө нь дараах шалгуурыг хангаж байгаа үед компани нь хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана. Ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн өгөөж олж авах магадлалтай бол ...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Мөн тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр оршиж байгаа /Оршин байх/, тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр байгууллагад хамаатай байх /Эрх ба үүрэг/, хөрөнгө, өр төлбөрийг зохих бүртгэлийн үнээр нь бүртгэсэн байх /Үнэлгээ/ зэрэг санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дараах зөвлөмжийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдан зөвлөлийн анхааралд хандуулж байна. Үүнд:

“Орон сууц өмчлөх тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон сууц хувьчлах тухай шийдвэрийг тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллага /Гишүүдийн хурал/ гаргах бөгөөд ийнхүү хувьчлахдаа энэ хуульд заасан зарчим, журмыг баримтална” гэж заасны дагуу дээр дурдсан 28 орон сууцыг хувьчлах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт дахин тавьж холбогдох шийдвэрийг гаргуулан, одоогийн эзэмшигчдэд нь шилжүүлж, компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасалт хийх.

2.10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж дүгнэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,655.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 4 зөвлөмж өгсөн.



2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Дөлгөөн хайрхан уул Аудит” ХХК аудит хийж “зөрчилгүй” дүгнэлт өгч, Менежментийн захидааар 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Материаллаг байдлыг аудитын төлөвлөлтийн үе шатанд “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны орлогын тайлангийн нийт орлогын 92,866.2 сая төгрөгийг суурь болгон авч, түүний 2 хувиар буюу 1,857.3 сая төгрөгөөр тодорхойлсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзсэн болно.

2.15. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа.

3. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидалын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

ҮАГ-ЫН АЖИГЛАЛТ

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК 2017 оны 12 сарын 31-ний байдлаар ОСНААУГ-аас 1548-MON(SF) дугаартай Дулааны үр ашгийн төслийн дамжуулан зээлийн гэрээний 1,398.2 сая төгрөг, 1492-MON(SF) дугаартай Эрчим хүчний хэмнэлтийн төслийн дамжуулан зээлийн гэрээний 125.1 сая төгрөг нийт 1,523.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд нийт авлагын үлдэгдлийн 40.1 хувийг эзэлж компанийн эдийн засгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь тус компани 2007-2008 онд ОСНААУГ-ын өмнөөс Сангийн яаманд төлсөн төлбөр бөгөөд авлага барагдуулах талаар ОСНААУГ-т удаа дараа хандсан боловч төлбөрийн чадвар байхгүй гэсэн шалтгаанаар төлөгдөөгүй өдийн хүрсэн байна.

2. Азийн хөгжлийн банкны урт хугацаат дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Эрдэнэт-Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-тай байгуулсан гэрээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүйгээс 2017 оны эцэст зээл, зээлийн хүүгийн 24.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3. Компанийн ТҮЗ-ийн 2015 оны 25 дугаар тогтоолоор 2015 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитыг “Голден пэйж Аудит” ХХК-иар гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулан урьдчилгаа төлбөрт 9.0 сая төгрөг төлж аудитын ажлыг эхлүүлсэн боловч Үндэсний аудитын газраас “Ворлд файнэнс Аудит” ХХК-иар аудит хийлгэх албан бичиг ирүүлснээр “Голден пэйж Аудит” ХХК-ийн аудитын ажил

ҮАГ-ЫН ЗӨВЛӨМЖҮҮД

Компанийн удирдлагад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Төслийн зээлийн гэрээний авлагын 1,523.3 сая төгрөгийг Эрчим хүчний зохицуулах хороо, ОСНААУГ-тай зөвшилцөн дулааны үнэ тарифт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх,
2. “Эрдэнэт-Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-иас авах дамжуулан зээл, зээлийн хүүгийн 24.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ авч ажиллах,
3. “Голден пэйж Аудит” ХХК-иас авах 3.0 сая төгрөгийн авлагын асуудлыг шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх,
4. 92 аж ахуйн нэгж байгууллагаас авах дулааны эрчим хүчний төлбөрийн 193.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулан барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

Авлага, өр төлбөрийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

01**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

цуцлагдаж, улмаар 6.0 сая төгрөгийг буцаан төлж, үлдэгдэл 3.0 сая төгрөгийг аудит хийсэн ажилтнуудын ажлын хөлс гэсэн үндэслэлээр төлөхөөс татгалзсан байна.

4. Тус компани тайлант оны эцэст 92 аж ахуйн нэгж байгууллагаас авах дулааны эрчим хүчний төлбөр 193.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Авлагын тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт суларч, найдваргүй авлага ихсэх, компанийн эдийн засагт сөргөөр нөлөөлөх, хууль эрхийн акт зөрчиgidөх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Асуудал 2 Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар

Тэргүүлэх ач
холбогдол № 2

ҮАГ-ЫН АЖИГЛАЛТ

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан хөрөнгийн тайлан тооцоог шалгаж үзэхэд 2017 онд үндсэн хөрөнгийн шинж чанартай 5 төрлийн нийт 7.0 сая төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг тоног төхөөрөмж /үүнд: аяга таваг угаагч төхөөрөмж-2, цаас устгагч-1, гагнуурын аппарат-2, трансформатор-3, ацителиний ком аппарат-2 ширхэг/-ийг худалдан авч бараа материалын дансанд бүртгэж зарлага болгосон байна.

Энэ нь Эрчим хүчний сайдын 2017 оны 46 дугаар тушаалаар баталсан эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 9 дүгээр зүйлийн 9.3-д “үндсэн хөрөнгө гэдэг нь нэгээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдах үйлдээрлэл, үйлчилгээ буюу захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр оршиж байгаа /Оршин байх/, тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр байгууллагад хамаатай байх /Эрх ба үүрэг/, хөрөнгө, өр төлбөрийг зохих бүртгэлийн үнээр нь бүртгэсэн байх /Үнэлгээ/, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллага, хууль тогтоох байгууллага, Сангийн яамнаас гаргасан дүрэм журамд нийцэж байх /Үнэн зөв байдал/ зэрэг санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Өмч хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт суларч, хөрөнгө үрэгдэх, ашиглал, шамшигдал үүсэх.

ҮАГ-ЫН ЗӨВЛӨМЖҮҮД

Бараа материалын дансанд бүртгэж зарлага болгосон 5 төрлийн нийт 7.0 сая төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авах.

Бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХАРИУ

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох

арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ТӨРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Асуудал 3 Актлаж данснаас хассан үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол № 2

ҮАГ-ЫН АЖИГЛАЛТ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар /ТӨБЗГ/-ын 2016 оны 229, 2017 оны 397 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тайлант онд нийт 4,275.2 сая төгрөгийн өртөгтэй 3228 хос метр дулааны шугамыг шинэчлэн солихоор тусгасан байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2017 оны зуны их засвараар нэр бүхий 34 байршилд ашиглагдаж байсан нийт 2,427.5 сая төгрөгийн өртөгтэй 3,622.5 хос метр дулааны хуучин шугамыг сольж, актлаж данснаас хасах саналыг 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 09/2441 дүгээр албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн болов ч тухайн ондоо шийдвэр нь гаралтай бөгөөд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 32 дугаар тогтоолоор данс бүртгэлээс хассан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1-д “Төрийн өмчийн хуулийн этгээд нь . . . цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах саналаа . . . Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

ЭРСДЭЛҮҮД

Өмч хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт суларч, хөрөнгө үрэгдэх, ашиглал, шамшигдал үүсэх.

ҮАГ-ЫН ЗӨВЛӨМЖҮҮД

- Актлаж данснаас хассан 2,427.5 сая төгрөгийн өртөгтэй 3,622.5 хос метр дулааны хуучин шугамын асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт дахин тавьж холбогдох шийдвэрийг гаргуулж авах,
- Цаашид үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй шугам хоолой болон бусад хөрөнгийг актлаж данснаас хасахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох зөвшөөрөл шийдвэр авч байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХАРИУ

Аудитын зөвлөмжийн хариу
холбогдох арга хэмжээ авч дарах
мэдэгдэнэ

01 ТӨРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
ЗӨВЛӨМЖИЙН ХАРИУ
“ЗОРЧИЛДАЙ
САНДАЛДХААНЫ ЭЛТ

Асуудал 4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналын талаар

Тэргүүлэх ач
холбогдол № 2

ҮАГ-ЫН АЖИГЛАЛТ

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК 2009-2016 онд ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн оны их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж Төрийн өмчийн хороогоор батлуулан нийт 1,078.2 сая төгрөгийн үнэ бүхий 1-2 өрөө 28 ширхэг орон сууцыг худалдан авч тухайн ажилтнуудад 50-иас 100 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож, “Орон сууц эзэмшүүлэх тухай гэрээ” байгуулан компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн бөгөөд орон сууцны Улсын бүртгэлийн гэрчилгээ нь эзэмшигч хувь хүмүүсийн нэр дээр бүртгэлтэй байна.

Эдгээр орон сууцыг тухайн онуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан гэсэн утгаар компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэж ирсэн бөгөөд бүтээмжийн зориулалттай бус, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн зардлын шинж чанартай хөрөнгө болох нь тогтоогдож байна.

Энэ нь “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 3 дугаар зүйлийн 3.4 “Үндсэн хөрөнгийн бодлого”-ын Тодорхойлолт хэсэгт “... бүтээгдэхүүн ажил үйлчилгээний зорилгоор ашиглагдаж, элэгдлийн үндсэн дээр өртөг зардалд анхны үнээ аажмаар шингээж байгаа биет хөрөнгүүдийг хамааруулна”, Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт хэсэгт “Үндсэн хөрөнгө нь дараах шалгуурыг хангаж байгаа үед компани нь хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана. Ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн өгөөж олж авах магадлалтай бол ...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ЫН ЗӨВЛӨМЖҮҮД

Дараах зөвлөмжийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдан зөвлөлийн анхааралд хандуулж байна. Үнд:

“Орон сууц өмчлөх тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон сууц хувьчлах тухай шийдвэрийг тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллага /гишигдүүлийн хурал/ гаргах бөгөөд ийнхүү хувьчлахдаа энэ хуульд заасан зарчим, журмыг баримталаа” гэж заасны дагуу дээр дурдсан 28 орон сууцыг хувьчлах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт дахин тавьж холбогдох шийдвэрийг гаргуулан, одоогийн эзэмшигчдэд нь шилжүүлж, компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасалт хийх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

01

ТӨРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Мөн тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр оршиж байгаа /Оршин байх/, тухайн өдөр хөрөнгө, өр төлбөр байгууллагад хамаатай байх /Эрх ба үүрэг/, хөрөнгө, өр төлбөрийг зохих бүртгэлийн үнээр нь бүртгэсэн байх /Үнэлгээ/ зэрэг санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт алдагдаж хөрөнгийн ашиглал, шамшигдал үүсэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

01

ТӨРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/төгрөгөөр/
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,230,530,970.91	2,216,782,812.49	
Дансны авлага	1,016,504,714.22	1,083,231,848.52	
Татвар, НДШ-ийн авлага	841,977,036.74	720,584,788.78	
Бусад авлага	1,804,984,547.06	1,846,522,963.30	
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	
Бараа материал	621,688,195.14	508,066,712.77	
Урьдчилж төлсөн зардал тооцоо	130,605,599.84	238,816,854.95	
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,646,291,063.91	6,614,005,980.81	
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	138,765,174,520.59	150,851,554,426.55	
Биет бус хөрөнгө	216,414,463.05	93,277,879.02	
Биологийн хөрөнгө	-	-	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	15,467,352,288.11	14,630,123,325.17	
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	
Хойшлогдсон татварын хөрөнгө	588,425,340.54	736,448,822.26	
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	155,037,366,612.29	166,311,404,453.00	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	162,683,657,676.20	172,925,410,433.81	
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	-	-	
Цалингийн өглөг	-	-	
Татварын өр	41,886,694.07	86,664,865.97	
НДШ-ийн өглөг	-	-	
Урьдчилж орсон орлого	671,456,096.82	157,657,050.50	
Бусад богино хугацаат өр төлбөр	38,288,884.93	96,933,572.00	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	751,631,675.82	341,255,488.47	
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	23,381,883,564.38	21,642,629,024.07	
Хойшлогдсон татварын өр	-	-	
Бусад урт хугацаат өр төлбөр	-	1,469,841,771.00	
Урт хугацаат өр төлбөрийн дүн	23,381,883,564.38	23,112,470,795.07	
Өр төлбөрийн нийт дүн	24,133,515,240.20	23,453,726,283.54	
Эздийн өмч	-	-	
Төрийн өмч	100,866,295,643.12	123,273,508,753.71	
Нэмж төлөгдсөн капитал	-	-	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	17,179,128,646.48	16,905,316,328.48	ТӨРИЙН АУДИТИН БААНЫ УЛАГА
Төсвийн санхүүжилт	22,407,213,110.59	10,651,725,701.30	(3,358,866,633.22)
Хуримтлагдсан ашиг	(1,902,494,964.19)	(3,358,866,633.22)	
Эздийн өмчийн дүн	138,550,142,436.00	149,471,684,150.27	
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	162,683,657,676.20	172,925,410,433.81	

ОДОГЖИН
САННАЛ/ҮНЭЛГЭЛТ

4.2 Аудит хийгдсэн орлогын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого (цэвэр)	87,939,202,270.31	91,787,731,430.24
Борлуулалтын өртөг	65,394,757,077.50	70,069,079,296.50
Нийт ашиг (алдагдал)	22,544,445,192.81	21,718,652,133.74
Түрээсийн орлого	-	-
Хүүгийн орлого	383,914,277.82	300,679,628.17
Ногдол ашгийн орлого	-	-
Бусад орлого	1,066,642,978.65	909,483,551.80
Борлуулалт, маркетингийн зардал	49,090,107.53	49,688,445.45
Ерөнхий ба удирдлагын зардал	19,569,688,041.72	20,583,828,870.53
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	903,360,916.30	980,705,568.79
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	636,374.40	(90,003.05)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(590,877,178.69)	(134,782,902.50)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,882,622,579.44	1,179,719,523.39
Орлогын татварын зардал	404,695,785.46	166,525,470.42
Татварын дараах ашиг (алдагдал)	2,477,926,793.98	1,013,194,052.97
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,477,926,793.98	1,013,194,052.97
Гадаад валютын хөрүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	2,477,926,793.98	1,013,194,052.97
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	95,064,980,909.12	5,385,549,908.00	17,920,521,302.98	(3,397,499,105.81)	114,973,553,014.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны запруулга	5,801,314,734.00	-	-	(1,592,942,715.51)	4,208,372,018.49
Залруулсан үлдэгдэл	100,866,295,643.12	5,385,549,908.00	17,920,521,302.98	(4,990,441,821.32)	119,181,925,032.78
Бусад дэлгэрэнгүй орлого	-	22,822,977,936.59	-	-	22,822,977,936.59
Өмчид гаргасан өөрчлөлт	-	(5,801,314,734.00)	-	(41,960,333.35)	(5,843,275,067.35)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(89,412,260.00)	(89,412,260.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	2,477,926,793.98	2,477,926,793.98
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(741,392,656.50)	741,392,656.50	-
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	100,866,295,643.12	22,407,213,110.59	17,179,128,646.48	(1,902,494,964.19)	138,550,142,436.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны запруулга	22,407,213,110.59	-	-	-	22,407,213,110.59
Залруулсан үлдэгдэл	123,273,508,753.71	22,407,213,110.59	17,179,128,646.48	(1,902,494,964.19)	160,957,355,546.59
Бусад дэлгэрэнгүй орлого	-	10,651,725,701.30	-	-	10,651,725,701.30
Өмчид гаргасан өөрчлөлт	-	(22,407,213,110.59)	-	-	(22,407,213,110.59)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(743,378,040.00)	(743,378,040.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,013,194,052.97	1,013,194,052.97
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(273,812,318.00)	273,812,318.00	-
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	123,273,508,753.71	10,651,725,701.30	16,905,316,328.48	(1,358,866,633.22)	149,471,684,150.27

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	96,799,628,751.04	102,193,543,856.18
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	96,223,519,683.49	101,695,931,681.15
Бусад мөнгөн орлого	576,109,067.55	497,612,175.03
Мөнгөн зарлагын дүн (-)	(88,423,973,278.59)	(92,975,307,640.98)
Ажиллагчдад төлсөн	(6,444,607,512.00)	(7,008,022,822.00)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,688,734,750.84)	(1,893,772,226.06)
Бараа материал худалдан авахад төлсөн	(1,002,516,692.74)	(926,172,303.72)
Ашиглалтын зардалд төлсөн	(1,702,877,722.44)	(1,721,231,183.96)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	(5,149,708,654.53)	(2,819,123,167.71)
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	(72,435,527,946.04)	(78,606,985,937.53)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,375,655,472.45	9,218,236,215.20
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	(9,594,242,842.65)	(9,488,516,330.57)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(8,467,891,390.00)	(7,466,788,329.00)
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,126,351,452.65)	(2,021,728,001.57)
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,594,242,842.65)	(9,488,516,330.57)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	701,124.56	311,977.13
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	701,124.56	311,977.13
Мөнгөн зарлагын дүн (-)	(729,708,499.18)	(743,780,020.18)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(606,121,489.02)	-
Төлсөн ногдол ашиг	(123,522,260.00)	(743,378,040.00)
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(64,750.16)	(401,980.18)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(729,007,374.62)	(743,468,043.05)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,947,594,744.82)	(1,018,748,158.42)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,178,125,715.73	01 ЗӨРЧИЛГҮЙ САНХҮҮГИЙН ДАЛГААРЫН ТӨГС
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,230,530,970.91	2,216,782,812.49